

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 5 дугаар хавсралт

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

2022.12.16

Улаанбаатар хот

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
<b>1. Монгол Улсын хууль</b>					
1	55.3	Төрийн албаны тухай 2017.12.07 Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2021-2024 оны ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг жил тутам гарган ажиллаж байна. Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг хамруулах 2022 оны сургалтын төлөвлөгөөнд нийт 20 арга хэмжээ тусгагдсан үүнээс 18 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 61 сургалт зохион байгуулагдсан. - Тайлант хугацаанд дотооддоо зохион байгуулсан сургалт 5, албан хаагчдыг хамарсан мэдээллийн цаг 2, Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан сургалт 34, Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан сургалт 2, Удирдлагын Ақдеми зохион байгуулсан сургалт 6, цахим сургалт 8 тус тус зохион байгуулагдсан ба давхардсан тоогоор 814 албан хаагч хамрагдав.	-	-

1	2	3	4	5	6
			<p>- Тайлант хугацаанд Ажилтан, албан хаагчдыг ажлын гүйцэтгэл үр дүнг улирлаар дүгнэн 250,061,248 төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 679,087,510 төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон байна. Ажилтны хоол унааны зардалд 581,063,100 төгрөгийг олгож байгууллагын дотоод журмын дагуу 15 ажилтан, албан хаагчдад 15 326 000 төгрөгний буцалтгүй мөнгөн тусламж олгосон байна.</p> <p>- Илүү цагийн болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг зохих хууль, журмын дагуу 290 ажилтан, албан хаагчид нийт 306,679,960 төгрөгний нэмэгдэл хөлсийг олгосон. Мөн төрийн албанд ажилласан жилийн судалгааг гарган Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу ажилласан жилийн нэмэгдэл болох 151,540,507 төгрөгийг олгосон.</p> <p>- Үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа 122 ажилтанг шагнаж урамшуулсан байна.</p>		
2	6.1	Хөдөлмөрийн тухай хууль 2021.07.02 Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл,	Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын 2021 оны 03 сарын 04 өдрийн А/19 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталсан. 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхлэх “Хөдөлмөрийн	-	-

1	2	3	4	5	6
		<p>арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно.</p>	<p>тухай хууль /шинэчилсэн найруулга/ нь хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын үндсэн эрх, үүргийг тодорхойлж, тэдгээрийн хоорондын зохистой тэнцвэрт байдлыг хангаж, онцлог бүхий цоо шинэ харилцаануудыг зохицуулсан. Хуулийн суурь зарчим үл ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглох хуулийн 6-р зүйлд заасны дагуу газрын даргын 2022 оны А/14 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-д өөрчлөлт оруулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Мөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэмд эзэлж байгаа харилцан ялгаатай үүргийг тэнцвэржүүлэх хүйсийн чиг баримжаанаас үүдэлтэй ялгаварлан гадуурхах, эрхийг хязгаарлах байдлыг зогсоох зорилгоор газрын нийт албан хаагчид “Нандин бүхнээ хамгаалья” уриан дор Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд нэгдсэн. Тайлант хугацаанд шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохтой холбоотой аливаа зөрчил байхгүй.</p>		
3	7.1	<p>Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие</p>	<p>Газрын даргын 2022 оны А/14 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-д өөрчлөлт оруулж үгээр, биеэр, цахимаар болон бусад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэх</p>	-	-

1	2	3	4	5	6
		<p>биедээ үгээр, биеэр, цахимаар болон бусад аливаа хэлбэрээр дараах байдлаар дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно</p>	<p>, хүчирхийлэл үйлдэхийг хориглосон заалтыг тусгаж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд дарамт, шахалт үзүүлэхтэй холбоотой аливаа зөрчил байхгүй.</p>		
4	8.1	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021.12.17 Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.</p>	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль шинэчлэгдэн 2022 оны 05 дугаар сарын 1-ны өдрөөс “Цахим хөгжлийн багц хууль” Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулиар нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай мэдээлэл гэж ангилсан бөгөөд хуульд заасны дагуу нээлттэй мэдээлэл болох Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээлэл үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүү, хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллийг <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> сайт, болон мэдээллийн самбарт цахим болон цаасан суурьтайгаар байршуулан ажиллаж байна.</p>	-	-

1	2	3	4	5	6
5	8.2	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021.12.17</p> <p>Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.</p>	<p>Тус газар нь байгууллагын дунд, богино хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, дүрмээр хүлээсэн чиг үүрэгт нийцүүлж, тэдгээрийн хэрэгжилт, үр дүнг тухай бүр байгууллагын цахим хуудаст шинэчлэн, нээлттэй байршуулж ажиллаж байна. Үүнд өөрийн чиг үүрэг, стратеги зохион байгуулалттай холбоотой 14 төрлийн мэдээллийг тогтмол байршуулж тайлан, мэдээг улирал, хагас жилээр, Нийслэлийн Засаг даргын А/93 дугаар захирамжаар батлагдсан байгууллагын бүтэц, зохион байгуулалтын схемийг мэдээллийн самбарт цаасан суурьтайгаар тус тус нээлттэй байршуулан ажиллаж байна.</p> <p><a href="http://khangardi.mn/?page_id=3634">http://khangardi.mn/?page_id=3634</a>  <a href="http://khangardi.mn/?page_id=3648">http://khangardi.mn/?page_id=3648</a>  <a href="http://khangardi.mn/?page_id=3868">http://khangardi.mn/?page_id=3868</a></p>	-	-
6	8.3	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021.12.17</p> <p>Мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.</p>	<p>Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, Хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд нээлттэй зарлаж байна. Тайлант хугацаанд 13 ажлын байрны 47 сул орон тоонд 150 горилогч материалаа ирүүлж, нөөцөд</p>	-	-

1	2	3	4	5	6
			<p>бүртгэгдсэн ба анкет хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийж, 92 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийн хянаж, үнэлэх журам, холбогдох бусад 12 төрлийн тайлан мэдээг тогтмол байршуулж, тайлан мэдээг улирал, хагас жилээр цахим хуудсанд байршуулж байна.</p> <p>Ажилтан, албан хаагчдын ур чадварыг холбогдох журмын дагуу улирал бүр дүгнэж, ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын хавсалтын дагуу ур чадварын нэмэгдлийг сар бүр олгосон болно.</p>		
7	8.4	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021.12.17</p> <p>Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана</p>	<p>Тайлант хугацаанд төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс заасан хугацаанд тухай бүр тайлан, мэдээг гаргаж, <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a>, тайлагнаж, байгууллагын цахим хуудас <a href="http://khangardi.mn/?page_id=3583">http://khangardi.mn/?page_id=3583</a> төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг байршуулан ажиллаж байна.</p>	-	-
8	31.1	<p>Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2021.12.17</p> <p>Энэ хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөс өмнө хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл</p>	<p>Газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/27 дугаар тушаалаар ажлын хэсэг томилогдож хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан (Хурууны хээ) биеийн давхцашгүй өгөгдлийг устгах үйл ажиллагааг зохион байгуулсан. Нийслэлийн Засаг захиргааны 4-н байр, нийт 154</p>	-	-

1	2	3	4	5	6
		хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг устгана.	ажилтан албан хаагчийн хурууны хээ агуулж буй файл, өгөгдлийн баазыг устгаж, давхцахгүй хувь хүний биометрик өгөгдөл болох нүүр царайгаар таниулах системд шилжүүлсэн.Мэдээллийн нууцыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, боловсруулан мэдээллийн эзний хүсэлтээр мэдээллийг устган хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.		
9	5.1	Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022.04.29 Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын схемийг мэдээллийн самбар, цахим хуудаст тогтмол байршуулж ажилласан. <a href="http://khangardi.mn/?page_id=3634">http://khangardi.mn/?page_id=3634</a> <a href="http://khangardi.mn/?page_id=3648">http://khangardi.mn/?page_id=3648</a> <a href="http://khangardi.mn/?page_id=3868">http://khangardi.mn/?page_id=3868</a>	Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд НЗД-ын 2022 оны А/656 захирамжаар Нийтлэг үйлчилгээний газрын гурван орлогч тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, даргыг газрын даргын Б/ 185,186 дугаар тушаалаар 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөр үүрэгт ажлаас нь чөлөөлж 24,497,942 төгрөгийн төсвийн хэмнэлт хийсэн. Мөн орлогч даргатай ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалах зэрэг хуулийн зөрчилгүй дэд, орлогч даргатай байхыг хориглоно.	-	-

1	2	3	4	5	6
10	12.1	Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно	Гар утасны зардал, .ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал, хэвлэлийн захиалгын төлбөр, хуулиар зөвшөөрөөгүй бусад зардлыг байгууллагын төсвөөр гаргалгүй хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	-	-
<b>2. Засгийн газрын тогтоол</b>					
1	1.1	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258 харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх	Ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг сахиулах арга хэмжээний хүрээнд тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлуудаас дурдвал: - Ажлын цаг ашиглалтыг сайжруулах талаар шат дараалсан арга хэмжээ авч, ажлаас хоцорсон, эрт тарсан болон хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр цагаа дутуу бүртгүүлсэн ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг тооцохдоо холбогдох журмын дагуу хасч тооцож байна. - Сахилга хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан ажилтан албан хаагчдын зөрчлийн талаарх мэдээллийг нээлттэй хүлээн авч, зөрчлийн шинжийг шалган хариуцлага хүлээлгэж байна. - Газрын даргын 2022 оны А/24	Ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлагыг чанд сахиулж, төрийн албан хаагчийн ёс зүйг дээдлэх талаар эрх бүхий байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн үйл ажиллагааны онцлогтоо нийцүүлэн жид бүр шат дараалсан арга хэмжээ авч ажиллаж 2021 онд 8 ажилтан зөрчил гаргасан бол 2022 онд 18 ажилтан холбогдох сахилгын болон ёс зүйн зөрчил гаргаж зөрчлийн тоо өмнө	-



1	2	3	4	5	6
			<p>Дугаар тушаалаар байгууллагын ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж, ёс зүйн зөрчлийн мэдээг олон эх сурвалжаар нээлттэй хүлээн авч байна.</p>	<p>оны мөн үетэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Тус газрын хөдөлмөрийн дотоод журам, Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.</p>	
2	1.2	<p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258 иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас</p>	<p>Газрын хэмжээнд тайлант хугацаанд нийт 124 өргөдөл ирснийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем <a href="http://www.erp.ulaanbaatar.mn">www.erp.ulaanbaatar.mn</a> сайтад бүртгэн 115 өргөдлийг бүрэн шийдвэрлэж, хариуг холбогдох этгээдэд танилцуулсан бол 9 өргөдөл шийдвэрлэх шатанд явж байна. Мөн хугацаанд өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэхтэй холбоотой</p>	<p>Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног байгаа шалтгаан нь ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалж буй тохилдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 79.2-т</p>	-

1	2	3	4	5	6
		<p>ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх</p>	<p>ямар нэгэн зөрчил гараагүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа хагас жилийнхээр 10 хоног байгаа нь өнгөрсөн жилийн мөн үеийхээс өссөн үзүүлэлттэй байна.</p>	<p>заасан хугацааг баримтлах болсонтой холбоотой юм.</p>	
3	1.3	<p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258 төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах</p>	<p>Газрын даргын 2022 оны А/01 дугаар тушаалаар тухайн жилд хамаарах ажил, албан тушаалын бүтцийн жагсаалтыг шинэчлэн баталснаар албан хаагчдын ажил үүргийн зөв, жигд хуваарилан ажлын ачааллыг бууруулсан. 2022 оны 01 сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ээлжийн амралттай байгаа ажилтныг орлон ажиллуулж, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй байх зарчмыг баримтлан ажиллаж байна. Мөн цаг үеийн шинж чанартай үйл ажиллагаа, арга хэмжээний үеэр ажилтан, албан хаагчдын ажлыг цагийн зөв зохион байгуулж, ажлын ачааллыг жигд хуваарилан, ажлын байрны давхардал хийдэл үүсгэхгүй, нэг ажилтанд хэт их ачаалал өгөхгүй</p>	<p>Ажлын байрны чиг үүргийн давхцал үүсгэлгүйгээр ажлын ачааллыг зөв цэгцтэй хуваарилах, хөдөлмөрийн сахилгыг чанд сахиулж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тайлант хугацаанд албан хаагчийг байгууллагын дотор шилжүүлэх, дэвшүүлэн томилох, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, чиг.</p>	-

1	2	3	4	5	6
			байхад тогтмол анхаарч ажиллаж байна.	үүргийг жигд хуваарилах арга хэмжээ авч ажиллалаа	
4	1.4	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258 төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх	Байгууллагын мэргэжлийн албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т заасан чадахуйн (мерит) болон шатлан дэвшүүлэх зарчмыг удирдлага болгон ажиллаж, албан хаагчийн ур чадвар, дадлага туршлага, ёс зүйн харилцаа хандлага, мэдлэг боловсрол зэрэг үзүүлэлтийг харгалзан 16 албан хаагчийг дэвшүүлэн томилсон байна. Тоног төхөөрөмж хариуцсан техникч Д.Гантамирыг мэдээлэл технологийн инженерээр, үйлчлэгч М.Хишиг-Эрдэнийг угтах үйлчилгээний ажилтнаар, угаагч Ш.Байгальмааг бэлтгэгч тогоочоор, Угтах ажилтан Н.Дэлгэртуяаг байр хариуцсан менежерээр, Үйлчлэгч Э.Маралтуяаг угтах үйлчилгээний ажилтнаар, хянагч оперотер Б.Мөнхцэцэгийг байр хариуцсан менежерээр, байр хариуцсан менежер Т.Азжаргалыг хүний нөөц, сургалт хариуцсан ажилтнаар, үйлчлэгч Б.Мөнхтуяа, Э.Одмааг угтах үйлчилгээний ажилтнаар, Зоогийн касс Д.Үүрцайх, Зөөгч Ж.Отгонцэцэг нарын байр хариуцсан менежерээр, зөөгч Э.Ариунтунгалагыг касс, агентлаг хариуцсан нярав Д.Уянгааг агентлаг	Ажилтан, албан хаагчдыг байгууллага дотор дэвшүүлэн томилох болсноор тэдгээрийн идэвхи санаачилгатай, тогтвор суурьшилтай ажиллах сэдэл бүрдэж буй нь өмнөх мөн үетэй харьцуулахад ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээ цуцлах байдал буурсан байна. Хасуулах саналтай.	-

1	2	3	4	5	6
			хариуцсан ахлах нягтлан бодогчоор, байр хариуцсан менежер Б.Мөнхцэцгийг агентлаг хариуцсан няраваар тус тус дэвшүүлэн томилсон байна.		
5	1.5	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258 төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох	Манай байгууллага нь Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан төрийн үйлчилгээний албан хаагчийн ангилалд хамаарах бөгөөд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд түр орлон гүйцэтгэж буй орон тоо байхгүй болно. Хасуулах саналтай.	-	-
6	1.6	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22	Жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөөтэй байгаа 30 ажилтан албан хаагч, хувийн болон эрүүл мэндийн шалтгаанаар урт хугацааны чөлөөтэй	Манай байгууллага нь хуульд заасан үндэслэлээр урт хугацааны чөлөөтэй байгаа 32	-

1	2	3	4	5	6
		<p>№ 2020_258  өрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх</p>	<p>байгаа 1 албан хаагч, нийт 31 албан хаагчийн ажлын байрны сул орон тоонд мөн тооны ажилтан, албан хаагчийг хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилуулж байна.</p>	<p>ажилтан, албан хаагчийн сул орон тоонд ажиллаж буй ажилтантай хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд бусад шалтгаанаар гэрээт ажилтан ажиллуулдаггүй болно. Хасуулах саналтай.</p>	
7	1.7	<p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258 төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа</p>	<p>Тайлант хугацаанд ёс зүйн зөвлөл 3 удаа хуралдаж 18 ажилтан, албан хаагчид холбогдох зөрчлийн шинж чанартай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн ба ажилтан, албан хаагчдад холбогдох ёс зүйн зөрчил тогтоогдож хурлын тэмдэглэлээр сануулах болон Хөдөлмөрийн тухай хуулийн 123-р зүйлийн 123.2.2-т заасан үндэслэлээр сануулах сахилгын шийтгэл оногдуулсан.</p>	<p>Ажилтан, албан хаагчдын сахилга, хариуцлагыг чанд сахиулж, төрийн албан хаагчийн ёс зүйг дээдлэх талаар эрх бүхий байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу үйл ажиллагааны онцлогтоо</p>	-

1	2	3	4	5	6
		<p>хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох</p>		<p>нийцүүлэн жил бүр шат дараалсан арна хэмжээ авч ажиллаж байна</p>	
8	1.8	<p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258 төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга</p>	<p>Ажилтан, албан хаагчдын гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх чиглэлээр үе шаттай ажлууд хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр 3 удаа сургалт зохион байгуулж нийт ажилтан албан хаагчдыг хамруулан ажиллалаа.</p>	-	-

1	2	3	4	5	6
		хэмжээг үр дүнтэй зохион байгуулах			
9	1.10	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258 ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах	2022 оны 01 сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 6 дугаар зүйл Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахыг хориглох, 7 дугаар зүйл Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох заалтыг тус тус үндэслэн газрын хөдөлмөрийн дотоод журамд газрын даргын 2022 оны А/14 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж аливаа хэлбэрээр ажилтан, албан хаагчид бие биеэ ялгаварлан гадуурхах байдлыг хориглосон бөгөөд уг үйлдлийг гаргасан ажилтан, албан хаагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахаар тусгасан.	Тайлант хугацаанд ажлын байран дахь хууль бус дарамт шахалт, ялгаварлан гадуурхсан үйлдлийн талаар ажилтан, албан хаагчаас ирсэн гомдол байхгүй байна.	-
10	5.1	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05 Дугаар 7 Эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын	Нийслэлийн Засаг захиргааны II байр Хангарди ордонд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 18 хэрэгжүүлэгч агентлаг үйл ажиллагаа явуулж байна. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэрийг уйгаржин монгол бичиг рүү хөрвүүлэх, нэр томъёог орчуулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж,.	-	-

1	2	3	4	5	6
		<p>мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх.</p>	<p>хаягжилтийг бүрэн уйгаржин монгол бичгээр хийн 1 давхарт байршуулсан</p>		
11	5.2	<p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05 Дугаар 7 Төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх</p>	<p>Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын албан ёсны сайт <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтлэх үйл ажиллагааг туршилтаар хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	-	-
12	5.3	<p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05 Дугаар 7 Төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших</p>	<p>Байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгч нь Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Монгол бичгийг хэрэглээнд албан ёсоор шилжих бэлтгэл ажлыг хангах , түүний бүрдэлд тавигдах үндсэн шаардлагыг судлан, бэлтгэл ажлыг ханган ажиллаж MNS 6395:2022 Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавигдах үндсэн шаардлагын сургалтад хамрагдан үйл турших</p>	-	-



1	2	3	4	5	6
			ажиллагаандаа хэрэгжүүлэхээр ажиллаж байна.		
13	5.4	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05 Дугаар 7 Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх	Монгол бичгийг төрийн бичиг болгохтой холбогдуулан уйгаржин монгол бичгийг албан хэрэгцээнд нэвтрүүлэх бэлтгэлийг ханган холбогдох сургалт МУЗГ-ын 7 дугаар тогтоол, НЗД-ын 02-03/373 хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд ННҮГ-ын ЗТСХ-ийн албан хаагчдад 2022 оны 02 дугаар сарын 2022 оны 03 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсан монгол бичгийн 2 удаагийн сургалт нийт 30 ажилтан албан хаагч, хамрагдсан.		-
14	5.5	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05 Дугаар 7 Төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/897 дугаар “Гадна хаягийн загвар батлах тухай” захирамжийн дагуу Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хаягжилт болон давхрын мэдээллийн самбарыг уйгаржин монгол бичгээр бичиж өөрчлөх ажлын бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.		-
15	1	Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2022.05.11 Дугаар 192 "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг	"Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн салбараас бусад төрийн	-	-

1	2	3	4	5	6
		<p>төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ"-г дор дурдсанаар өөрчилж, 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.</p>	<p>үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ"-г өөрчилсөнтөй холбогдуулан Газрын даргын 2022 оны А/33 дугаар тушаалаар газрын нийт албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг шинэчлэн тогтоож 2022 оны 05 сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөн тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p>		
16	1.1	<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.05.25 Дугаар 203 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг</p>	<p>Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд НЗД-ын 2022 оны А/656 захирамжаар Нийтлэг үйлчилгээний газрын гурван орлогч даргыг газрын даргын Б/ 185,186 дугаар тушаалаар 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөр үүрэгт ажлаас нь чөлөөлж тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p>	-	-

1	2	3	4	5	6
		<p>хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх</p>			
17	2	<p>Журам шинэчлэн батлах тухай 2020.12.09 Дугаар 206 Энэ журмыг үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулан баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>Дотоод хяналт, Хяналт, үнэлгээ шинжилгээ хариуцсан ажилтан Засгийн газрын 206 дугаар тогтоолын дагуу нийт алба хаагчдын тайланд хяналт, үнэлгээ шинжилгээ хийн ажиллаж байна.</p>	-	-
18	2	<p>Журам батлах тухай 2022.05.18 Дугаар 201 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай</p>	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль шинэчлэгдэн 2022 оны 05 дугаар сарын 1-ны өдрөөс “Цахим хөгжлийн багц хууль” Нийтийн мэдээллийн ил.</p>	-	-

1	2	3	4	5	6
		<p>хууль болон энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төсөвт байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай</p>	<p>тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулиар нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай мэдээлэл гэж ангилсан бөгөөд хуульд заасны дагуу нээлттэй мэдээлэл болох Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээлэл үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүү, хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллийг <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> сайт, болон мэдээллийн самбарт цахим болон цаасан суурьтайгаар байршуулан ажиллаж байна</p>		
<b>3. Нийслэлийн Засаг даргын захирамж</b>					
1	1	<p>Журам батлах тухай №2015-А/633 2015.07.29 “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам”-ыг нэгдүгээр , “Ажил хүлээлцэх хуудасны загвар”-ыг хоёрдугаар, Тойрох хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.</p>	<p>Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь ажилтан, албан хаагчтай ажил хүлээлцэхдээ Нийслэлийн Засаг даргын А/633 дугаар захирамжийн хавсралтад заасан , ажил хүлээлцэх хуудасны загвар, тойрох хуудасны загварыг Хөдөлмөрийн дотоод журамд заан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p>	-	-

1	2	3	4	5	6
2	1	<p>Журам батлах тухай №2021-А/52/ 2021.02.02</p> <p>“Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам”-ыг шинэчлэн 1 дүгээр, “Хяналтын дагалдах хуудасны загвар”-ыг 2 дугаар, “Төсөл ирүүлсэн саналын товъёгийг загвар”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.</p>	<p>Нийтлэг үйлчилгээний газар нь захирамжлалын баримт бичгийг гаргахдаа Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/52 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан хяналтын дагалдах хуудасны загварын дагуу боловсруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд газрын даргын 206 тушаалд хяналтын дагалдах хуудасны дагуу боловсруулагдсан байна.</p>	-	-
3	1	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай №2021-А/115/ 2021.02.26</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны арга хэмжээний</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөө” дунд хугацааны бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилтийн явцад улирал бүр тайлан мэдээг гаргаж тайлант хугацаанд 4 удаа хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэн холбогдох газарт заасан хугацаанд тайлганаж ажиллаж байна. Тус хөтөлбөрт Нийслэлийн Нийтлэг Үйлчилгээний газарт тухайлан заасан заалт байхгүй бөгөөд байгууллийн үйл ажиллагаатай уялдуулан мөрийн хөтөлбөрийн 8 заалтын хэрэгжүүлэн тайлан мэдээг тогтмол гаргаж байна.</p>	-	-

1	2	3	4	5	6
		<p>төлөвлөгөөг 1 дүгээр, Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг 2 дугаар хавсралтаар баталсугай.</p>			
4	2	<p>Нийслэлийн 2020-2021 оны өвөлжилтийн дүн, 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай №2021-А/382 Нийслэлийн 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд инженерийн хангамжийн байгууллагууд болон бусад холбогдох газруудын хэрэгжүүлсэн ажиллах шаардлагатай ажлын жагсаалтыг хавсралтаар баталж, 2021 оны батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжих инженерийн шугам сүлжээ, авто зам тохижилтын ажлын нэгдсэн</p>	<p>2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажил 2021 оны намар хангагдсан тул хяналтаас хасуулах саналтай.</p>	-	-

1	2	3	4	5	6
		<p>төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжилтэд хяналт тавьж 2021 оны 09 сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга нар болон холбогдох байгууллагын удирдлагад даалгасугай.</p>			
5	3	<p>2022 оныг “Хотын иргэний жил” болгон зарлах тухай №2022- А/01 Нийслэлийн иргэдэд хотын соёлыг төлөвшүүлэх, дүрэм стандартыг сурталчлах, хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэх, амьдрах орчныг сайжруулах, эрүүл мэндийг анхаарах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодит үр дүнд хүрэхүйц ажлыг санаачлан зохион байгуулж, ажиллахыг бүх шатны байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.</p>	<p>Удирдлагын акидемтай хамтран зохион байгуулсан 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр “Страктеги төлөвлөгөө боловсруулах, онол арга зүй” сэдэвт сургалт албан хаагч-12 Нийслэлийн Хүний хөгжлийн төвтэй хамтран 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй, гадаад дүр төрх” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.Сургалтад 32 албан хаагч хамрагдсан. Монгол бичгийг төрийн бичиг болгохтой холбогдуулан уйгаржин монгол бичгийг албан хэрэгцээнд нэвтрүүлэх бэлтгэлийг ханган холбогдох сургалт МУЗГ-ын 7 дугаар тогтоол, НЗД-ын 02-03/373 хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд ННҮГ-ын ЗТСХ-албан хаагчдад зохион байгуулсан монгол бичгийн 2 удаагийн сургалт 2022 оны 02 дугаар сарын 2022 оны 03 дугаар</p>	-	-

1	2	3	4	5	6
			сарын 20-ны өдрүүдэд 30 албан хаагч хамрагдсан. Монгол Улс даяар нийт хүн амыг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 1 жилийн турш Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24 дэх заалт “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг дэмжиж ажилтан, албан хаагчдыг бүрэн хамрагдах ажлын хүрээнд сайн дураар нийт 121 ажилтан хамрагдаж нийт албан хаагчдын 50%-г эзлэж байна		
6	2	Дүрэм шинэчлэн батлах тухай №2022-А/93 2022.01.27 Дүрмийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар (Х.Эрдэнэбилэг)-т хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг НЗДТГ (Т.Оюунчимэг)-т тус тус үүрэг болгосугай.	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/93 дугаар захирамжаар Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, байгууллагын мэдээллийн самбар, khangardi.mn сайтад байршуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж НЗДТГ-ын холбогдох хэлтэст тайлан мэдээг хүргүүлэн ажилласан.	-	-
7	1	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцалсантай	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцлах тухай” 66 дугаар	-	-



1	2	3	4	5	6
		<p>холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай №2022-А/180 2022.02.14 Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын “Шар түвшин”-д шилжсэнтэй холбогдуулан хүн, хуулийн этгээдийн бүх төрлийн үйл ажиллагааны хязгаарлалтыг цуцалсугай.</p>	<p>тогтоол Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцалж 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн цар тахлын “Улбар шар” түвшнийг “Шар” түвшинд шилжүүлэн ажиллаж байна.</p>		
8	2	<p>Ажлын хэсэг байгуулах тухай №2022-А/578 Биеийн давхцахгүй өгөгдөл (гар хурууны хээ)-ийг цуглуулахад үндэслэл болгосон дүрэм, журмыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуультай нийцүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулж, тайлагнаж тайлагнахыг нийслэлийн харьяа бүх шатны байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>Газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/27 дугаар тушаалаар ажлын хэсэг томилогдож хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан (Хурууны хээ) биеийн давхцашгүй өгөгдлийг устгах үйл ажиллагааг зохион байгуулсан. Нийслэлийн Засаг захиргааны 4-н байр, нийт 154 ажилтан албан хаагчийн хурууны хээ агуулж буй файл, өгөгдлийн баазыг устгаж, давхцашгүй хувь хүний биометрик өгөгдөл болох нүүр царайгаар таниулах системд шилжүүлсэн. Мэдээллийн нууцыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, боловсруулан мэдээллийн эзний хүсэлтээр мэдээллийг устган хуулийн болон Нийслэлийн Засаг даргын</p>	<p>Нийт ажилтан албан хаагчийн хурууны хээ агуулж буй файл, өгөгдлийн баазыг устгаж, давхцашгүй хувь хүний биометрик өгөгдөл болох нүүр царайгаар таниулах системд шилжүүлж тухайн захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажилласан тул тухайн захирамжийг хяналтаас хасуулах саналтай байна.</p>	-

1	2	3	4	5	6
			захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		
9	2	Нийслэл хотын ялгамж чанарыг илтгэх тэмдгийг батлах тухай №2022-А/768 2022.06.03 Ялгамж чанарыг илтгэх тэмдгийг нийслэлийн бүх шатны төр захиргааны байгууллагууд үйл ажиллагаандаа тогтмол ашиглахыг үүрэг болгосугай.	Нийслэлийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс шингэсэн ялгамж чанарыг илтгэх тэмдгийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилтан албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, үйл ажиллагаандаа тогтмол ашиглахыг үүрэг болгож хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	-	-
10	1	Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022.06.09 № 2022-А/789 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д зааснаас бусад байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа. Нийслэлийн өмчид бүртгэлтэй суудлын автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Нийслэлийн өмчийн	Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 06 дугаар сарын 09-ны өдрийн А/789 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралт “Дуудлагын автомашинаар үйлчлүүлэх журам” 2 дугаар хавсралт “Дуудлагын автомашинаар үйлчлүүлэх эрх бүхий байгууллагын жагсаалт”-д заасны дагуу суудлын автомашин ашиглаж захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	-	-

1	2	3	4	5	6
		харилцааны газарт хүргүүлж, 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай.			
11	1	Журам шинэчлэн батлах тухай 2022.08.15 № 2022-А/1049 “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.	Тайлант хугацаанд тус журмын дагуу байгууллагын өргөдөл гомдлын тайлан, мэдээг 2 удаа гаргаж ажилласан бөгөөд ажилтан, албан хаагчдаас нийт 252 өргөдөл ирснийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системд бүртгэн 252 өргөдлийг бүрэн шийдвэрлэж өргөдөл гаргагчид танилцуулсан байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 15 цаг 11 минут байна.	-	-
12	1	Журам шинэчлэн батлах тухай 2022.08.23 № 2022-А/1106 “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ	Хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах, тэдгээрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн байгууллагын үйл ажиллагааг 2023 оноос үнэлж дүгнэхтэй холбогдуулан захирамжийн хэрэгжилтийн бэлтгэл	-	-

1	2	3	4	5	6
		хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.	ажлыг ханган нийт ажилтан, албан хаагчдад мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.		
13	1	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2022.10.21 №22-А/1357 Засгийн газрын 2018 оны 62 дугаар, 2022 оны 223 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгын хүрээнд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, Налайх дүүргийг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр хүртэлх хугацаанд "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал"-ын зэрэгт шилжүүлсүгэй.	Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээнд хяналт тавьж, мэдээлэл өгч ажиллаж байгаа бөгөөд Сонгинохайрхан дүүргийн 26, 36 дугаар хорооны 23 түлшний цэгийн холбогдох мэдээллийг тайлант хугацаанд 10 удаагийн давтамжтай холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.		
4. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл					
1	4	НЗД-ын 2022 оны 02 дугаар хурлын тэмдэглэл хяналтад авсан хууль тогтоомж,	Хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр Нийслэлийн Засаг даргын 2017 оны		

1	2	3	4	5	6
		<p>тогтоол шийдвэрийн заалтын хэрэгжилтийг хангах ажилбар тус бүрээр задлан байгууллагын болон алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэг бүрчлэн тусгаж, гүйцэтгэлийн явц, үр дүнг байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар улирал тутам хэлэлцэж, удаашралтай байгаа заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов.</p>	<p>A/335 дугаар захирамжийн дагуу нийт ажилтан, албан хаагч заасан хугацаанд тайлан мэдээг хүргүүлэн ажиллаж байна. Мөн улирал бүр байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p>	-	-
2	1	<p>НЗД-ын 2022 оны 20 дугаар хурлын тэмдэглэл “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөө” дунд хугацааны бодлогын баримт бичигт тус газарт тухайлан хэрэгжүүлэхээр заасан заалт байхгүй боловч байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн хэрэг улирал</p>		

1	2	3	4	5	6
		<p>хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” болон “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах, удаашралтай хэрэгжиж байгаа арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг 2022 оны зорилтод түвшинд хүргэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад</p>	<p>бүр 8 заалтын хэрэгжүүлэн тайлан мэдээг гаргаж нийт хоёр удаа хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэн холбогдох газарт заасан хугацаанд тайлагнаж ажиллаж байна.</p>		
5. Нийслэлийн Иргэдийн хурлын төлөөлөгчдийн тогтоол					
1	1	<p>Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай 2020.12.04 Дугаар 02/09 “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг, түүний хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээний</p>	<p>Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газарт тухайлан заасан заалт байхгүй бөгөөд тус газар нь үйл ажиллагаандаа нийцүүлэн 5 заалтын хэрэгжилтийг 2 удаа тайлагнаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэсэн ба хагас жилийн хэрэгжилтийг газрын даргын зөвлөлийн хурлаар танилцуулан ажилласан.</p>	-	-

1	2	3	4	5	6
		шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хавсралт ёсоор баталсугай.	.		
2	1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020.12.04 Дугаар 02/10 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөө” дунд хугацааны бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилтийн явцад улирал бүр 8 заалтын хэрэгжүүлэн тайлан мэдээг гаргаж нийт хоёр удаа хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэн холбогдох газарт заасан хугацаанд тайлагнаж ажиллаж байна.	-	-
<b>6. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол</b>					
1	1	Журам батлах тухай 2017.06.07 Дугаар 90 “Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам”-ыг хавсралтаар баталсугай.	Уг тогтоолоор баталсан “Нийслэлийн эрх зүйн сан эрхлэн хөтлөх журам”-ын 2.1, 2.2 дугаар зүйлд тус тус заасны дагуу газрын даргын тушаалыг улсын нэгдсэн бүртгэл ublegal.mn сайтад тухай бүр бүртгэж байна.	-	5 дугаар сараас эхлэн ublegal.mn сайт ажиллахгүй болсон.
2	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хүртээмжийг сайжруулах тухай	Тайлант хугацаанд нийслэлийн засаг захиргааны байрууд, дэд төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, гарцыг сайжруулах,	-	-

1	2	3	4	5	6
		<p>2021.12.20  Дугаар 210 Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэг эрхийг хангах, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хүртээмжтэй болгох, барилга байгууламж, зам талбай, нийтийн тээврээр саадгүй зорчих эрхийг хангах чиглэлээр батлагдсан хууль, тогтоомжийг Нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах холбогдох байгууллага албан тушаалтанд үүрэг, чиглэл өгч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/-д үүрэг болгосугай.</p>	<p>засварлах, орчин нөхцөлийг бий болгохоор иргэдэд зориулсан тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин 8 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.</p>		

**ТАЙЛАН ХЯНАСАН:**

ЗАХИРГАА ТӨЛӨВЛӨЛТ САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Ю.ХҮСЛЭН